



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 658

танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Т.Баярчимэгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-

006021327

2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Т.Баярчимэг Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Т.Баярчимэгийн мөрийн хөтөлбөр (.....хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Т.Баярчимэгд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2024-2028 оны орон нутгийн ИТХ-ын сонгуульд бие даан нэр дэвшиж буй Төгсбаяр овогтой Баярчимэгийн мөрийн хөтөлбөрийн жагсаалт

1. Жижиг дунд үйлдвэрлэл

- 1.1 Монгол архи, айраг савлаж борлуулахыг иргэдтэй уулзах санал солилцох
- 1.2 Амжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийг жижиг дунд үйлдвэрлэлийн төсөлд хамруулахыг удирдах шатанд уламжлах
- 1.3 Жижиг дунд үйлдвэрлэл сонирхсон иргэдийн судалгааг авах

2. Мал аж ахуй

- 2.1 Малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх, бусад төрлийн өвчнөөс сэргийлэх ажлыг малын эмчтэй хамтран жил бүр тогтмол хийх
- 2.2 Сүү, махны чиглэлийн малын үүлдэр нэвтрүүлэх, үүлдэр угсааг алдагдуулахгүй өгсөх тал дээр хяналт тавих

3. Байгаль орчин

- 3.2 Шаардлагатай булаг шандыг хашаажуулах ажлыг эрчимжүүлэх
- 3.3 Ойт хээрийн түймэрээс сэргийлэх, хор хөнөөлийг таниулах сурталчигааг мэргэжлийн байгууллагад санал тавих
- 3.4 Ховордсон ургамал, амьтаны судалгааг гаргах
- 3.5 Дунд гармны модон гүүрийг сэргээн засварлахыг удирдах шатанд уламжлах

4. Эрүүл мэнд

- 4.2 Бүх насны иргэдийг амны хөндийн үзлэгт хяналт тавьж идэвхтэй хамруулах
- 4.3 Хуванцар савны хэрэглээний судалгааг гаргаж хэрэглээг багасгах
- 4.4 Эрт илрүүлгийн үзлэг дээр хяналт тавих

Мөрийн хөтөлбөр боловсруулсан Т.Баярчимэг

Холбоо барих утас: 95809584